



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 19 өдөр

Дугаар А/593

Ховд

Хуучин 1, 2, 3, 4 дүгээр 30 айлын орон сууцны барилгын гадна фасадны засварын ажилд дүгнэлт гаргах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4-ийн "а", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар "Рашаант дарцагт" ХХК-ийн хийж гүйцэтгэсэн Хуучин 1, 2, 3, 4 дүгээр 30 айлын орон сууцны барилгын гадна фасадны засварын ажилд ажлын тоо хэмжээнд тусгагдаагүй нэмэлтээр хийгдсэн ажлыг нягтлан шалгаж нэмэлт гэрээ байгуулан санхүүжилтийг шийдвэрлэх боломжтой эсэх талаар шийдвэр гаргах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Б.Баярсүх

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд: Н.Ганзориг

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Б.Туулайтулга

- Жаргалант сумын Засаг даргын орлогч

Д.Эрдэнэбат

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Б.Гантогоо

- "Рашаант дарцагт" ХХК-ийн захирал

Нарийн бичгийн

дарга: Б.Жамбалдорж

- Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн

2. Тус ажлыг шийдвэрлэх боломжтой эсэх талаар ажлын хэсгийн дүгнэлтийг гаргаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Баярсүх/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН

№ 2021
Zah A/593 Kh